



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Н.ТАВИНБЭХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.10.04 № 38

Асуулт тавих тухай

Улаанбаатар хотод нийт 33 агуулахад сайжруулсан түлш нөөцөлж, 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 40 цэгээр борлуулж эхэлсэн. Гэвч цаг агаар огцом хүйтэрсэн тул айл өрхүүдийн түлшний хэрэглээ нэмэгдэж, борлуулалтын цэгүүдэд ихээхэн дараалал үүссэн талаар тойргийн иргэд, сонгогчдоос санал, шүүмжлэл ирүүлж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:


1. "Тавантолгой түлш" ХХК өдөрт 2,500-3,000 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай. Гэвч сүүлийн үед шахмал түлш болон түүний барьцалдуулагчийн нөөц хомстож, түгээлт муу байна гэх яриа иргэдийн дунд гараад байна. Иймд сайжруулсан түлшний хомстол хэзээ, ямар шалтгааны улмаас үүссэн талаар;
2. Нэг өрхөд ногдох түлшний хангамж, хүртээмж болон цаашид нөөцийг хэрхэн нэмэгдүүлэх талаар;
3. Хөшөөтийн уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлын явцын талаар тус тус тодорхой хариу ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд бэлтгэж ирүүлэхийг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХЦЭЦЭГ

2021000149